

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 06

№ Т/55

Улаанбаатар хот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ҮҮРЭГТ АЖЛААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, “Эм жи эл акуа” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.21.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Эм жи эл акуа” ХК-ийн гүйцэтгэх захирал Сэр-Од овогтой Алтантуяагийн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авч, 2026 оны 02 сарын 06-ны өдрөөр тасалбар болгон гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлж, түүнтэй байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г дуусгавар болгосугай.
2. С.Алтантуяад үүрэгт ажлаа 2026 оны 02 сарын 06-ны өдрөөр тасалбар болгон ажил хүлээлцэх акт үйлдэн, хүлээлгэж өгөхийг үүрэг болгосугай.
3. Гүйцэтгэх захирлын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:
Комиссын дарга:
 - ТУЗ-ийн дарга Л.БилгүүнКомиссын гишүүд:
 - ТУЗ-ийн гишүүн О.Сансар
 - ТУЗ-ийн гишүүн Б.Ундрал
 - ТУЗ-ийн НБД Г.Намхайдорж
 - Ерөнхий нябо Д.Бат-Ирээдүй
4. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагын баг, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодод даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/ Л.БИЛГҮҮН /